

**Монгол Улсын 2027 оны төсөвт уул уурхайн салбараас төвлөрөх орлого төлөвлөлтөд дүн шинжилгээ хийх ажлын даалгавар**

2026 оны 9 дүгээр сар

**1. Үндэслэл**

Монгол Улсын төсөв өндөр хэмжээний алдагдалтай байгаа энэ үед төсвийн орлого төлөвлөлтийг бодитой хийх нь чухал юм. Иймд УИХ-д өргөн баригдаад буй 2027 оны улсын төсвийн төсөлд уул уурхайн салбараас олох орлогыг төлөвлөсөн байдалд дүн шинжилгээ хийж, анхаарах шаардлагатай асуудлуудыг олон нийтийн анхааралд оруулах, УИХ-д санал, дүгнэлт хүргүүлэх нь чухал байна.

**2. Судалгааны ажлын зорилго**

Энэхүү судалгаа нь 2027 оны улсын төсвийн төсөлд уул уурхайн салбараас олох орлогыг төлөвлөсөн байдалд дүн шинжилгээ хийж, асуудал дэвшүүлэх зорилготой.

**3. Гүйцэтгэх ажил**

Зөвлөх нь Засгийн газрын 2027 оны төсвийн төсөлд уул уурхайн салбараас олох орлогыг төлөвлөсөн байдалд дүн шинжилгээ хийж, бодитой эсэхэд дүгнэлт өгч түүнийгээ хэлэлцүүлэг, уулзалтад танилцуулах ажил гүйцэтгэнэ.

**4. Зорилтот хэрэглэгчид**

Судалгааны дүнгийн зорилтот хэрэглэгчид нь бодлого боловсруулагчид болон олон нийт, иргэний нийгэм байна.

**5. Хүлээлгэж өгөх бүтээгдэхүүн:**

Ажил гүйцэтгэгч нь дараах бүтээгдэхүүнүүдийг хуваарьт заасны дагуу ННФ-д хүлээлгэж өгнө. Үүнд:

|   | <b>Бүтээгдэхүүн</b>                           | <b>Хугацаа</b>                   |
|---|-----------------------------------------------|----------------------------------|
| 1 | Дүн шинжилгээний эхний тайланг ННФ-д ирүүлэх  | 2026 оны 10-р сарын 13-ны дотор  |
| 2 | Дээрх судалгааны дүнг нийтэд танилцуулах      | 2026 оны 10-р сарын 22-ны дотор  |
| 3 | Дээрх судалгааны эцсийн тайланг ННФ-д ирүүлэх | 2026 оны 10-р сарын 25-ний дотор |

**6. Мэдээллийн эх сурвалж**

Судалгааг хийхдээ дор дурдсан болон бусад холбогдох баримт бичгүүдийг ашиглана. Үүнд:

- Монгол Улсын 2027 оны төсвийн төслийн баримт бичиг (дэлгэрэнгүй танилцуулга, тооцоолол)
- Төсвийн мэдээллийн холбогдох цахим хуудаснууд
- Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын холбогдох хууль, тогтоомжууд
- Холбогдох төрийн байгууллагууд
- Бусад эх сурвалжууд

## **7. Ажил гүйцэтгэх хугацаа, төсөв:**

Ажлын удирдамжийн 3-р зүйлд заасан ажлуудыг 2026 оны 10-р сарын 1-нээс 25-ны хооронд гүйцэтгэнэ.

### **Судалгааны ажлын төсөв:**

Судалгааны хүрээнээс хамаарч судалгааны төсвийн дээд хязгаар 5 сая төгрөг байна.

Зөвлөх нь Нээлттэй нийгэм форумтай нягт хамтран ажиллах ба судалгааны бүтээгдхүүнүүдийг 5-р зүйлд заасан хуваарийн дагуу ирүүлнэ.

## **8. Судалгааны ажилд тавигдах бусад шаардлага, хэмжээ, хэлбэр**

Гэрээт ажилд ашигласан дагалдах материал, судалгааны эх бичвэрийн файл, цахим хуудас зэргийн жагсаалтыг ажлын гүйцэтгэлд хавсаргана.